

## **ХРИСТИЙН ЕРТӨНЦ БА “АУГАА ИХ МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРЭН” НОМЫН ТУХАЙ**

*(С.В. Аксенов, А.Г.Юрченко нарын орчуулга, судалгаа)*

*Л.Оюунгэрэл\**

2002 онд Санкт-Петербург хотод хэвлэгдсэн энэ номонд (Христианский мир и “Великая Монгольская Империя” Материалы францисканской миссии 1245 года, -474 с.) Ромын Пап ламын элч Плато Карпинийг дагалдан явсан Польшийн Бенедиктын аян замын тэмдэглэлийг хуулбарлан авч “Тартаруудын түүх” тэмдэглэл нэртэй хэвлүүлсэн Ц. де Бридиа-гийн номыг Оросын эрдэмтэн С.В.Аксенов, А.Г.Юрченко нар анх удаа латин хэлнээс орос хэлнээ орчуулж А.Г.Юрченко-гийн судалгаа, танилцуулгыг хавсарган хэвлүүлжээ. Эл ном нь А.Г.Юрченкогийн бичсэн “Монголын эзэнт гүрэн дэх өдөр тутмын амьдрал”, “Эзэнт гүрэн ба сансар огторгуй” гэсэн гурвал номын нэг нь юм.

Уг ном нь I Вавилоны цамхаг дээрээс харсан нь; II Ц. де Бридиа-гийн “Тартаруудын түүх” тэмдэглэлийн орос хэл дээрх орчуулга; III Судалгаа ба судалгаанд холбогдох материалууд гэсэн гурван хэсэг, тайлбараас бүрджээ. Санкт-Петербург хотын эрдэмтэн А.Г.Юрченкогийн судалгааны маргаангүй давуу тал бол латин, орос, англи, герман, франц болон бусад хэл дээрх бараг бүх үндсэн сурвалж бичгүүдийг ашиглажээ. Нийт 55 сэдвээр түүх, утга зохиолын тайлбарыг өрнө, дорнын олон хэл дээр гарсан 500 гаруй бүтээлээс иш татан хийжээ.

С.В.Аксенов, А.Г.Юрченко нарын латин хэлнээс орос хэлнээ орчуулсан Ц. де Бридиагийн “Татарын түүх” бол Ромын Пап Иннокентий IV-ын элчээр 1245 онд Хархорумд очсон Плато де Карпинийг дагалдан явсан Польшийн Бенедиктын тэмдэглэлийг хуулбарлан авч хэвлүүлсэн ном юм. Анх 1965 онд америкийн түүхч Г.Д.Пейнтер XV зууны латин эхээр Ц. де Бридиагийн тэмдэглэлийг товчлон хэвлүүлсэн ажээ. Харин Ц. де Бридиа нь Польш Бенедиктын тэмдэглэлээс Монголын эзэнт гүрний түүхийн талаарх зохиомол зүйлийг (“Чингис хааны тухай роман” гэж нэрлэгдэх болсон) илүү дэлгэрэнгүй, нягт нямбай хуулбарлан авчээ.

Номын нэн сонирхолтой, шинэлэг тал нь гэвэл А. Г. Юрченко Монголын эзэнт гүрний түүхийн талаарх сурвалжуудыг судлах арга зүйн асуудлуудыг хөндсөн байна. Түүний үзэж байгаагаар XIII зууны үеийн өрнө, дорнын сэтгэлгээний хэв загвар тэс өөр байсан учраас ашигласан сурвалжаас шалтгаалан тэс өөр, бүр өөр хоорондоо зөрчилтэй дүгнэлтэнд

\* Л.Оюунгэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

ч хүрч болно гэжээ. Тэрээр бичихдээ: “Долоон зуун жил өнгөрсөн боловч судлаачдын дунд монголын байлдан дагуулалтын талаарх мэтгэлцээн үргэлжилсээр байна. Азийн нүүдэлчдийн түүхэнд юу нь үнэн, юу нь худал болохыг өнөөдөр ялгаж салгахад хэцүү болжээ. Чингис хааны цэргүүдийн ялагдашгүй хүч чадлын талаарх цуу яриаг монголчууд өөрсдөө ч зохиосон байж болно”<sup>1</sup> гэжээ.

Монголын эзэнт гүрний түүхийн сурвалжууд үзэл суртал, хөтөлбөрийн шинжтэй<sup>2</sup> гээд Монголын эзэнт гүрнийг дотроос нь харж бичсэн албан ёсны сурвалжуудад Монголын Нууц Товчоо, Жүвейни, Рашид-ад-Дин, Марко Поло-гийн зохиол зэргийг нэрлэжээ. Харин Өрнөдийнхний сурвалжууд, тухайлбал М.Парисын эмхэтгэл, Плато Карпини, Рубрукийн аян замын тэмдэглэл ба бусад зохиолуудыг “гаднаас нь ажиглагч иргэншлүүдийн бүтээл” гэжээ. Монголын эзэнт гүрний талаарх сурвалжуудыг бүхэлд нь судалж ангилах шаардлагатай гэсэн А.Г.Юрченкогийн санал зөв зүйтэй гэдэг нь мэдээж билээ. Дэлхийн монгол судлаачид эх сурвалжуудыг өөр хооронд нь харьцуулан судалсаар байгаа боловч эх бичгүүдийг орчин үеийн мэдээллийн технологийн тусламжтай түүх, улс төр, сэтгэл зүй, хэл шинжлэлийн үүднээс ангилж дүгнэлт хийж амжаагүй байгаа билээ. Хэдий тийм боловч бидний бодлоор А.Г.Юрченко өрнө, дорнын сэтгэлгээний өвөрмөц онцлогийг хэт туйлшруулж байгаа мэт. Монголын Нууц Товчоо нь монголын эзэнт гүрний албан ёсны үзэл баримтлал гэдэг түүний дүгнэлтийг бүрэн дэмжиж байгаа боловч эртний монголчуудын хувьд “албан ёсны” үзэл баримтлалууд нь үнэнд ихэд ойр байсан нь бусад сурвалжуудтай харьцуулахад нотлогдож байгаа юм. Учир нь Нууц Товчоо зохиолд ганцхан өгүүлбэрт багтааж дүгнэсэн зүйлийн цаана олон сар, жилээр үргэлжилсэн түүхт үйл явдлуудыг нэгтгэн дүгнэсэн байдаг. Жишээлбэл Нууц Товчооны 257-д Тохучар Чингис хааны зарлигийг зөрчиж Герат хотын “хан Мэлигийн хязгаар балгасыг ахуулж тариачныг даулижээ. (довтолж дээрэмдэн тариачдыг олзолжээ) Хан Мэлиг балгадаа ахуулдав хэмээн дайжин хөдөлж, Жалачин бээр Султанд нийлжээ. Жалачин султан, хан Мэлиг хоёр Чингис хааны эсрэг морилжээ” гэжээ. Эл үйл явдал жишээлбэл араб, перс хэл дээрх сурвалж бичигчдийн сонирхлыг татаагүй. Харин Нууц Товчоонд тэмдэглэгдэн үлдсэн шалтгааны талаар эрэгцүүлэн бодоход уг зохиолын шинж чанарыг ч илтгэн харуулж байгаа нь илт байна. Дээрх үйл явдал монгол сурвалж бичигчийн анхаарлын төвд байсны шалтгаан гэвэл дайны үеэр Чингис хааны баримталж байсан тактикт хор хохиролтой үйлдэл байжээ; учир нь Тохучарыг дайрахаас өмнө Герат хотын захирагч хан Мэлигт Чингис

хааны зарлигийг хүргэж түүний хот балгадыг довтолж сүйтгэхгүй гэж амалсан байжээ. Энэ жишээн дээрээс харсан ч монголчуудын “албан есны үзэл суртал” нь дайн, байлдааны үеэр хааны зарлигийг ёсчлон дагаагүй үнэн түүхийг өгүүлжээ гэж хэлж болно. Ер нь бол аль ч эх сурвалжид монголын байлдан дагуулалт, Монголын эзэнт гүрний түүхийг хэсэгчилэн харуулсан учраас тэдгээрийг харьцуулж байж дундаас нь түүхэн үйл явцыг таньж мэдэж болно.

А.Г.Юрченкогийн хийсэн гол дүгнэлт гэвэл монголын эзэнт гүрний тухай албан есны домгоос гадна албан бус, эзэнт гүрний эсрэг үзлээр бичсэн зохиол, бүтээлүүд байжээ гэжээ. Ц. де Бридиагийн хуулж авсан “Таргарын түүх” үүний нэг жишээ гэж тэрээр үзжээ. Ц. де Бридиагийн номонд Чингис хааны гурван зүгт хийсэн зохиомол дайн байлдаануудын тухай өгүүлж байгаа бөгөөд монголчуудын дайж ялсан улсуудыг жагсаасан ба тэдгээр нь 1. Канана 2. Солангууд, 3. Каранит, 4. Кергис, 5. Космир, 6. Комук, 7. Буритебет - волки-псы, 8. Паросцит, 9. Брутах гээд монголчуудад дийлдээгүй улс орнууд - Нарайргэн, Нохой газар,<sup>3</sup> Аугаа их Энэтхэг, Каспийн ууланд түгжигдсэн улс гэжээ. А.Г.Юрченко дээрх мэдээллийг ялангуяа Чингис хаан аянгал цохиулж бие барж байгаа тухай мэдээллийг Хархорум хотод монголын байлдан дагуулалтыг буруушаасан өөр үзэл бодолтой хүмүүс зохиосон гэж үзээд тэр үеэс эхлэн Чингис хааны тухай хуурамч домгийг Македоны Александрын домгоос санаа авч зохиох болсон гэж үзжээ. Эдгээр мэдээллийг Польш Бенедикт, Плано Карпини нарт Хархорумд амьдарч байсан хүмүүс, монголчууд өөрсдөө ярьсан гэж А.Г.Юрченко үзэж байгаа нь үнэн бололтой. Учир нь дээрх улс орнуудын талаарх мэдээлэл монгол хэл дээрх сурвалжуудад ч бас байгаа билээ. Жишээлбэл “Алтан Товч”-д “Сүмбэр уулын өмнөд тал нь Улаан-ли-гийн (Төв Азийн) тал буй. Замбутив ертөнц хэмээмү. Нохой улс хүрэн өнгөт буюу. ...Эрээн улс ганц хөлт улс буюу”<sup>4</sup> гэсэн бөгөөд “Эваны улс Хэрэн нэрт газар барин аж”<sup>5</sup> “Тэргүүн үгүй улс”, “Эрээн ганц хөлт улс”-ын тухай<sup>6</sup> өгүүлсэн байдаг.

Түүнчилэн “Хөх сударт” бичихдээ: “9 сард Тэмүжин Солонгосын зүүн хойно байх Горлусын наран хаанд очив, улмаар мөрнийг гэтэлж Горлусын зүүн хойно байх нохой толгойт улс, жич түүний зүүнд байх Охин зүст улсыг дайлан дагуулав. Улмаар Солонгос улсад очив” гэжээ.<sup>7</sup> “Нохой иргэн” улсыг монголчууд ялж чадаагүй тухай Пэн Да-я, Сюй Тин нарын “Хар татааруудын тухай товч тэмдэглэл”-д бас дурссан ажээ.<sup>8</sup> Бидний бодлоор дээрх үл мэдэгдэх улс орнуудын тухай мэдээллийг судлах шаардлагатай мэт. “Алтан Товч”, “Хөх судар” зэрэг зохиолыг харьцуулахад зарим мэдээлэл жишээлбэл “Хөх судар”-т өгүүлж

байгаа Чингис хааны анхны аян дайнуудын тухай мэдээ, мөн Чингис хааныг нас нөгцсөний дараах үеийн мэдээг нарийвчлан судалвал дээрх асуултуудад хариулж болмоор санагдаж байгаа билээ.

Харин Чингис хааны аян дайны тухай зохиомол домогт үндэслэн бусад эх сурвалжийн түүхэн бодит шинж чанарт эргэлзэж байгаа нь арга зүйн хувьд маргаантай юм. Харин аливаа эргэлзээний бүтээлч талыг нь тодруулъя гэвэл түүхийн эх сурвалж судлалыг текстологийн судалгаанаас гадна илүү өргөн хүрээнд, тухайлбал түүх, хэл шинжлэл, утга зүйн, сэтгэл судлалын, соёл судлалын үүднээс нарийвчлан судлах шаардлага улма бүр нэмэгдэж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

### ИШЛЭЛ

1. Grousset, *Le Conquerant du Monde, Vie de Gengis-khan*, ed. lbin Michel, Paris, 1944, p. 275
2. S.Sultan Shah Nomam, *A brief report on the Kabul Manuscript*, ОУ Монголч эрдэмтний V их хурал, №3, УБ, 1992, х. 288
3. R. Grousset, *Le Conquerant du Monde, Vie de Gengis-khan*, ed. Albin Michel, Paris, 1944, p. 294
4. Б. Бартольд, *Сочинения*, М., 1963, том 1, с. 127
5. M. Prawdin, *The Mongol Empire its rise and legacy*, London, 1940, p. 552
6. Рашид-ад-Дин, *сборник летописей*, М, 1952, том 1, с. 231
7. Ш.Нацагдорж, *Чингис хааны цадиг*, УБ, 1991, х. 322
8. S.Sultan Shah Nomam, *A brief report on the Kabul Manuscript*, ОУ Монголч эрдэмтдийн V их хурал, №3, УБ, 1992, х. 288